



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/142/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох

Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
Х.ДАШЗЭВЭГ ТАНАА

2024.02.24 № УВА-2026/192/НА-СТА-Танс
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

8525050505

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,659,451.42	210,971,376.36
33	АВЛАГА	140,032.52	21,636,461.06
335	Бусад авлага	140,032.52	21,636,461.06
3351	Байгууллагаас авах авлага	140,032.52	21,636,461.06
35	БАРАА МАТЕРИАЛ	173,519,418.90	189,334,915.30
351	Түүхий эд материал	143,476,953.69	156,640,550.09
35130	Эм боох материал	143,476,953.69	156,640,550.09
354	Хангамжийн материал	30,042,465.21	32,694,365.21
35410	Бичиг хэргийн материал	1,772,300.00	3,540,000.00
35420	Аж ахуйн материал	27,060,165.21	27,902,165.21
35450	Барилгын засварын материал	00.00	42,200.00
35470	Бусад хангамжийн материал	1,210,000.00	1,210,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	613,073,573.50	609,879,116.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	613,073,573.50	609,879,116.94
392	Биет хөрөнгө	584,157,573.50	580,963,116.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	525,773,562.84	525,773,562.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,378,311.12	-79,493,170.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	189,000,000.00	262,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-126,349,974.09	-180,705,974.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	180,754,053.08	193,637,553.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-116,655,637.46	-146,005,344.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,830,519.40	40,081,954.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,343,639.15	-35,652,464.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,530,000.00	6,530,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,530,000.00	-6,530,000.00
39217	Ном	527,000.00	527,000.00
393	Биет бус хөрөнгө	28,916,000.00	28,916,000.00
39301	Програм хангамж	635,000.00	635,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-635,000.00	-635,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,916,000.00	28,916,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	786,733,024.92	820,850,493.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	582,760.14	45,256,497.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	582,760.14	45,256,497.96
413	Өглөг	582,760.14	45,256,497.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	6,170,511.89
4136	Бусад өглөг	582,760.14	39,085,986.07
41361	Байгууллагад төлөх өглөг	582,760.14	36,771,986.07
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	2,314,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	786,150,264.78	775,593,995.34
51	Засгийн газрын хувь оролцоо	786,150,264.78	775,593,995.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	819,365,247.44	819,365,247.44
51101	Өмч: - төрийн	819,365,247.44	819,365,247.44
512	Хуримтлагдсан үр дүн	-123,862,435.13	-134,418,704.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-123,862,435.13	-123,862,435.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-10,556,269.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,647,452.47	90,647,452.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	786,733,024.92	820,850,493.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,251,800,745.90	6,463,780,225.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	579,306,958.90	945,867,405.26
120	Нийтлэг татварын бус орлого	579,306,958.90	945,867,405.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	579,306,958.90	945,867,405.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,672,493,787.00	5,517,912,820.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,475,215,107.00	4,083,098,930.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,475,215,107.00	4,083,098,930.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	197,278,680.00	1,434,813,890.53
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,150,000.00	1,304,384,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,687,200.00	97,075,930.53
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,441,480.00	33,353,960.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,470,268,053.61	6,474,336,495.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,470,268,053.61	6,474,336,495.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,500,092,040.04	3,752,558,790.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,161,776,877.82	1,182,347,622.09
210101	Үндсэн цалин	657,834,365.19	633,844,355.77
210102	Нэмэгдэл	322,862,351.00	318,980,458.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,287,532.15	119,009,373.46
210104	Урамшуулал	110,792,629.48	110,513,434.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,150,156.58	135,384,038.58
210201	Тэтгэврийн даатгал	100,881,954.43	92,105,678.86
210202	Тэтгэмжийн даатгал	11,700,497.29	10,861,627.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,938,105.20	5,512,773.92
210204	Ажилгүйдлийн даатгал	5,135,245.86	5,381,450.40
210205	Эрүүл мэндийн даатгал	20,494,353.80	21,522,507.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,549,460.14	68,532,961.55
210301	Гэрэл, цахилгаан	4,968,130.14	6,001,562.55
210302	Түлш, халаалт	56,120,000.00	56,120,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,461,330.00	6,411,399.00
2104	Хангамж, бараа материалын зардал	118,266,462.38	52,210,936.00
210401	Бичиг хэрэг	9,376,240.00	1,419,550.00
210402	Тээвэр, шатахуун	78,465,162.00	33,837,299.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,602,350.38	8,657,386.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,822,710.00	8,296,700.00
2105	Нормативт зардал	769,765,699.48	562,448,796.76
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	753,845,699.48	562,448,796.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,920,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,649,540.00	470,088,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	462,466,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	796,900.00	00.00
210604	Урсгал засвар	15,852,640.00	7,621,800.00
2107	Томилот, зочны зардал	68,626,400.00	43,960,300.00
210702	Дотоод албан томилот	68,626,400.00	43,960,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,710,686.00	901,376,542.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	928,934.00	898,949,702.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,538,500.00	1,384,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,052.00	257,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,255,100.00	515,500.00
210807	Газрын төлбөр	262,300.00	236,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,596,757.64	336,209,393.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,563,150.00	68,708,150.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,920,500.00	181,980,924.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,113,107.64	85,520,318.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,970,176,013.57	2,721,777,705.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,941,692,989.00	2,370,958,735.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	55,028,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,278,036,989.00	1,060,276,236.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,606,237,200.00	1,310,682,499.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,390,600.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,483,024.57	350,818,969.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,483,024.57	350,818,969.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-218,467,307.71	-10,556,269.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,296,854.43	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,296,854.43	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,296,854.43	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-219,764,162.14	-10,556,269.44

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,672,493,787.00	5,518,017,820.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,672,493,787.00	5,517,912,820.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,475,215,107.00	4,083,098,930.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,475,215,107.00	4,083,098,930.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	197,278,680.00	1,434,813,890.53
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,150,000.00	1,304,384,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,687,200.00	97,075,930.53
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,441,480.00	33,353,960.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,672,493,787.00	5,518,017,820.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,672,493,787.00	5,518,017,820.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,693,838,343.43	2,796,240,115.47

2101	Цалин хөле болон нэмэгдэл урамшил	1,161,776,877.90	1,176,037,077.68
210101	Үндсэн цалин	657,834,365.19	626,590,570.21
210102	Нэмэгдэл	322,862,351.08	318,980,458.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,287,532.15	119,009,373.16
210104	Урамшуулал	110,792,629.48	111,456,676.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,722,429.15	135,384,038.58
210201	Тэтгэврийн даатгал	99,454,227.10	92,105,678.86
210202	Тэтгэмжийн даатгал	11,700,497.29	10,861,627.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,938,105.10	5,512,773.92
210204	Ажилгүйдлийн даатгал	5,135,245.86	5,381,450.40
210205	Эрүүл мэндийн даатгал	20,494,353.80	21,522,507.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,966,700.00	61,976,549.68
210301	Гэрэл, цахилгаан	4,968,130.14	6,001,562.55
210302	Түлш, халаалт	55,537,239.86	49,563,588.13
210303	Цэвэр, бохир ус	3,461,330.00	6,411,399.00
2104	Хангамж, бараа материалын зардал	106,164,010.38	46,319,433.00
210401	Бичиг хэрэг	7,808,100.00	2,621,450.00
210402	Тээвэр, шатахуун	78,516,262.00	31,470,575.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,561,600.38	7,953,308.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,278,048.00	4,274,100.00
2105	Нормативт зардал	39,545,950.00	29,505,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,989,950.00	29,380,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,556,000.00	125,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,633,440.00	153,421,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,025,800.00	149,020,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,280,500.00	00.00
210604	Урсгал засвар	19,327,140.00	4,401,900.00
2107	Томилолт, зочны зардал	68,266,400.00	42,290,300.00
210702	Дотоод албан томилолт	68,266,400.00	42,290,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,110,686.00	904,359,542.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,123,030.00	901,920,102.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,538,500.00	1,384,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,956.00	270,240.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,375,100.00	515,500.00
210807	Газрын төлбөр	262,300.00	236,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,651,850.00	246,946,274.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,069,250.00	72,694,334.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,582,600.00	174,251,940.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,978,655,443.57	2,721,777,705.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,950,172,419.00	2,370,958,735.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	55,028,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,349,905,419.00	1,060,276,236.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,541,743,200.00	1,310,682,499.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,495,600.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,483,024.57	350,818,969.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,483,024.57	350,818,969.08
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	819,365,247.44	90,647,452.47	-123,862,435.13	00.00	786,150,264.78
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	819,365,247.44	90,647,452.47	-123,862,435.13	00.00	786,150,264.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	819,365,247.44	90,647,452.47	-123,862,435.13	00.00	786,150,264.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,556,269.44	00.00	-10,556,269.44
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	819,365,247.44	90,647,452.47	-134,418,704.57	00.00	775,593,995.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайланг оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,098,217,715.00	4,083,203,930.00	15,013,785.00	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,098,217,715.00	4,083,203,930.00	15,013,785.00	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,400,485,685.00	1,385,366,686.00	15,118,999.00	99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,141,620,227.32	1,141,620,227.32	0.00	100
210101	Үндсэн цалин	626,590,570.21	626,590,570.21	0.00	100
210102	Нэмэгдэл	323,596,781.04	284,563,607.88	39,033,173.16	88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,976,200.00	119,009,373.16	-39,033,173.16	149
210104	Урамшуулал	111,456,676.07	111,456,676.07	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,527,600.00	131,527,600.00	0.00	100
210201	Тэтгэврийн даатгал	89,472,400.00	89,472,400.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	10,536,300.00	10,536,300.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,317,900.00	5,317,900.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	5,240,200.00	5,240,200.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	20,960,800.00	20,960,800.00	0.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,976,549.68	61,976,549.68	0.00	100
210301	Гэрэл, цахилгаан	9,101,400.00	6,001,562.55	3,099,837.45	66
210302	Түлш, халаалт	48,244,000.00	49,563,588.13	-1,319,588.13	103
210303	Цэвэр, бохир ус	4,631,149.68	6,411,399.00	-1,780,249.32	138
2104	Хангамж, бараа материалын зардал	40,162,168.00	33,382,683.00	6,779,485.00	83
210401	Бичиг хэрэг	2,621,450.00	2,621,450.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	27,476,900.00	22,187,815.00	5,289,085.00	81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,299,318.00	4,299,318.00	0.00	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	862,700.00	00.00	862,700.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,901,800.00	4,274,100.00	627,700.00	87
2105	Нормативт зардал	3,169,300.00	1,345,000.00	1,824,300.00	42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,044,300.00	1,220,000.00	1,824,300.00	40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	125,000.00	125,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,625,200.00	2,401,900.00	3,223,300.00	43
210604	Урсгал засвар	5,625,200.00	2,401,900.00	3,223,300.00	43
2107	Томилолт, зочны зардал	6,875,200.00	4,302,800.00	2,572,400.00	63
210702	Дотоод албан томилолт	6,875,200.00	4,302,800.00	2,572,400.00	63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,824,740.00	3,105,342.00	719,398.00	81

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	666,000.00	665,902.00	98.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	1,384,600.00	1,384,600.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,240.00	270,240.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,234,800.00	515,500.00	719,300.00	42
210807	Газрын төлбөр	236,100.00	236,100.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5704700.00	5704584.00	116.00	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,386,300.00	5,386,184.00	116.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	318,400.00	318,400.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2697732030.00	2370958735.98	326,773,294.02	88
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,697,732,030.00	2,370,958,735.98	326,773,294.02	88
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,060,276,236.00	1,060,276,236.00	0.00	100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,637,455,794.00	1,310,682,499.98	326,773,294.02	80
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,097,983,230.00	3,756,325,421.98	341,657,808.02	92
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,097,983,230.00	3,756,325,421.98	341,657,808.02	92
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,097,983,230.00	3,756,325,421.98	341,657,808.02	92
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	38.00	4.00	90
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	32.00	4.00	89
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,434,813,890.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,434,813,890.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,410,873,429.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		34,416,850.36
210102	Нэмэгдэл		34,416,850.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,856,438.58
210201	Тэтгэврийн даатгал		2,633,278.86
210202	Тэтгэмжийн даатгал		325,327.47
210203	ҮОМШӨ-ний даатгал		194,873.92
210204	Ажилгүйдлийн даатгал		141,250.40
210205	Эрүүл мэндийн даатгал		561,707.93
2104	Хангамж, бараа материалын зардал		12,936,750.00
210402	Тээвэр, шатахуун		9,282,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,653,990.00
2105	Нормативт зардал		28,160,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		28,160,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		151,020,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		149,020,000.00
210604	Урсгал засвар		2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		37,987,500.00
210702	Дотоод албан томилолт		37,987,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		901,254,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		901,254,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	241,241,690.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		67,308,150.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		173,933,540.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		23,940,461.06
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		23,940,461.06
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,410,873,429.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,410,873,429.47
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,282,747,538.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		97,075,930.53
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		31,049,960.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэхэд төр, иргэн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаа хүчин чармайлтыг өрнүүлж монгол хүнийг эрүүл урт наслалтад хүргэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор

батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,117.5 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	140.0	21,636.5	21,496.5
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	173,519.4	189,334.9	15,815.5
Үндсэн хөрөнгө	613,073.6	609,879.1	-3,194.5
Нийт хөрөнгө	786,733.0	820,850.5	34,117.5
Өр төлбөр	582.7	45,256.5	44,673.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	786,150.3	775,593.9	-10,556.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	786,733.0	820,850.5	34,117.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данс байна. Үүнд: Авлага дансны үлдэгдэл 21,636.5 мянган төгрөг болж 21,496.5 мянган төгрөгөөр өссөн нь хавдрын аяны хүрээнд орж ирсэн санхүүжилт гүйлгээ хийгдээгүй байхад төрийн сангийн гүйлгээ хаагдаж авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 183,334.9 мянган төгрөг болж, 15,815.5 мянган төгрөгөөр өсөхөд эм боох материал, бичиг хэргийн материалын үлдэгдэл өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 609,879.1 мянган төгрөг болж, -3,194.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 45,256.5 мянган төгрөг болж өссөн нь батлагдсан төсөв хуваарийн дагуу олгогдоогүйн улмаас хүн амын орлогын албан татвар 7,170.5 мянга, түлш халаалтын зардал 7,139.0 мянга, шуудан холбооны зардал 670.8 мянга, урсгал засварын зардал 950.7 мянга, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 1,950.2 мянга, тээвэр шатахууны зардал 1,945.0 мянга, 21,496.5 мянган төгрөгөөр хавдрын аяны хүрээнд орж ирсэн санхүүжилт гүйлгээ хийгдээгүйтэй холбоотой үүссэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 775,593.9 мянган төгрөг болж, 10,556.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,415,804.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг зардлыг 332,706.0 мянган бууруулж 2025 онд улсын төсвөөс 4,083,098.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,083,098.9 мянган төгрөгийн санхүүжилтээс бүрдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,756,325,4 мянган төгрөг зарцуулж 326,878.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71603 -Эрүүл мэндийн бодлого , удирдлага , 80101-Үйл ажиллагааны зардал	1,376,174.2	1,376,174.2	0	100%
2	71603 -Эрүүл мэндийн бодлого , удирдлага, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,697,732.0	2,370,958.7	326,878.5	87,8 %
3	71603 -Эрүүл мэндийн бодлого , удирдлага, 83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал	666,9	665,6	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв буюу байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 97,075.9 мянга, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,282,747.5 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 31,049.9 мянга, нийт 1,410,873.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Гүйцэтгэлээр цалингийн зардалд 34,416.8 мянга, ажил олгогчоос олгох шимтгэлд 3,856.4 мянга, тээвэр шатахууны зардалд 9,282.8 мянга, шуудан холбоо, интернэтийн төлбөр 3,653.9 мянга, эм боох материалд 28,160.0 мянга, урсгал засварын зардалд 2,000.0 мянга, багаж техник хэрэгсэл 149,020.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 37,987.5 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 173,933.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 901,254.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 67,308.2 мянга, нийт 1,410,873.4 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 23,940.5 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрүүл мэндийн газар нь шатах, тослох материал худалдан авах цахим тендер зарлаж зардалд 22,187.8 мянган төгрөгийн тээвэр шатахуун худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,470,268.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 54,702.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 43,762.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,474,336.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 64,743.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 51,794.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн газрын тухай хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитын ерөнхий судалгааны дүн

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	635.0	Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ 385.0 мянга, архив бичиг хэргийн 250.0 мянган төгрөгийн 2 программ байна.
2	Унаа, хоолны зарцуулалт	119,009.4	2025 онд 119,009.4 мянган төгрөг батлагдаж 119,004.4 мянган төгрөг зарцуулсан байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал	4,452.0	2025 оны дотоод сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу 10,500.0 мянган төгрөг төсөвлөж, 4,425.0 мянган төгрөгийн 7 удаагийн сургалт сурталчилгаа явуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0	Зардал гараагүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0	Зардал гараагүй
6	Орон тоо	1,176,037.1	Аймгийн засаг даргын 2025 оны А/234 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоо шинэчлэн 43 орон тоогоор баталж, 4 харуул, 1 жолоочийн орон тоог цомхотгол хийж чөлөөлсөн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 166, хугацаа хоцроож оруулсан мэдээлэл 3, мэдээлэл оруулах хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,318.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,018.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 300.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Залруулсан алдаа:

Эрүүл мэндийн газар нь мөнгөн гүйлгээний журналд 13,018.0 мянган төгрөгийг шууд зардалд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.1 Төлбөрийн акт

Эрүүл мэндийн газар нь төсвийн хөрөнгөөс 300.0 мянган төгрөгөөр гар утасны нэгж худалдан авсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгөөс 300.0 мянган төгрөгөөр гар утасны нэгж худалдан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг нотлох баримтын хамт Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн сууриар бүртгэсэн	1	13,018.0					1	13,018.0				
Дүн	1	13,018.0					1	13,018.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гар утасны нэгж олгосон	1	300.0	1	300.0								
Дүн	1	300.0	1	300.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/



2026 оны 02 сарын 24-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/12/1А 2070415
УВА-2026/112/НА-СТА-ТМЗ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь төсвийн хөрөнгөөс 300.0 мянган төгрөгөөр гар утасны нэгж худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 дэх заалтад “үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсвийн мөнгөөр худалдаж авсан гар утасны нэгж 300 000 /гурван зуун мянга/ төгрөгийг Эрүүл мэндийн газрын дарга Х.Дашзэвэгээр төлүүлж Мэргэжлийн хяналтын газрын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар¹т Эрүүл мэндийн газрын дарга Х.Дашзэвэг, нягтлан бодогч Ц.Цэцэгбал нарт хариуцуулав.

¹ Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

8525110051

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.МӨНХТОГТОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ